



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 134

Номгон

“Баянхонгор-Баптист” сүмийн  
зөвшөөрлийн хугацааг тогтоох тухай

“Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, “Төр, сүм хийдийн харилцааны тухай” хуулийн 9 дүгээр зүйл, Баянхонгор-Баптист сүмийн хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 1 дүгээр багийн нутагт үйл ажиллагаа явуулж буй “Баянхонгор-Баптист” сүмийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг 1 жилээр тогтоосугай.

2. “Баянхонгор-Баптист” сүмийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Шашны асуудал эрхэлсэн зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Д. ОТГОНБАЯР



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 135

Номгон

Монгол Улсын “Сайн малчин” цолоор  
шагнуулахаар уламжлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын сайн малчин шалгаруулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мал аж ахуйн салбарт олон жил, үр бүтээлтэй ажиллаж Монгол Улсын Сайн малчны болзол хангасан малчдыг ажлын үзүүлэлтээр эрэмбэлэн 1.Өлзийт сумын хоёрдугаар багийн малчин Дарамын Пүрэв, 2.Баянцагаан сумын хоёрдугаар багийн малчин Цэвэлмаагийн Батболд, 3.Гурванбулаг сумын гуравдугаар багийн малчин Лхамсүрэнгийн Бямбасамбуу, 4.Эрдэнэцогт сумын дөрөвдүгээр багийн малчин Бямбаагийн Ган-Очир, 5.Богд сумын хоёрдугаар багийн малчин Өлзийгийн Сүхцэрэн, 6.Бөмбөгөр сумын нэгдүгээр багийн малчин Моломын Мөнх-Эрдэнэ, 7.Хүрээмарал сумын хоёрдугаар багийн малчин Лхамаагийн Балдангомбо, 8.Жинст сумын нэгдүгээр багийн малчин Сойзодмаагийн Түвшин, 9.Богд сумын нэгдүгээр багийн малчин Доржийн Батсуурь нарыг Монгол Улсын “Сайн малчин” цолоор шагнуулахаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд уламжилсугай.

2. Нэр бүхий малчдын материалыг холбогдох байгууллагад хүргүүлэхийг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР